



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/171

Бор-Өндөр сум

**Үер усны ослоос урьдчилан сэргийлэх
ажлын хэсэг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн “Үер усны ослын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үер усны ослоос урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Үер усны ослоос урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг чанартай зохион байгуулж танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д даалгасугай.
4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг сумын гамшгийн эрсдлийн сангаас зохих журмын дагуу санхүүжүүлэхийг санхүү албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ

Засаг даргын 2025 оны 07-р
сарын 07-ний өдрийн А/Т.1-р
захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

З.Ууганжаргал

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Э.Баттулга

Гал түймэр унтраах, аврах 49 дүгээр ангийн
захирагч, Хошууч

Э.Ганцэцэг

Ангиллын сургалт сурталчилгаа,
урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан
мэргэжилтэн, Ахлах ахлагч

Б.Баярбаясгалан

Байгаль хамгаалагч

И.Энхтуяа

1 дүгээр баийн Засаг дарга

У.Пүрэвсүрэн

2 дугаар багийн Засаг дарга

Д.Мөнгөнтуяа

3 дугаар багийн Засаг дарга

Ч.Саруулмөнх

4 дугаар багийн Засаг дарга

Р.Цэндсүрэн

Мал эмнэлэгийн тасгийн Тархвар зүйч